



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ  
**БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ**

15171 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Их тойруу-1, Утас/Факс: 32-07-34,  
E-mail: info@barilga.gov.mn

2022-07-05

№ 1/1848

танай \_\_\_\_\_

-ны № \_\_\_\_\_

-Т

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА С.МАГНАЙСҮРЭН ТАНАА,  
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Тус байгууллага нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2022 оны эхний хагас жилийн байдлаар иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг нэгтгэн хүргүүлж байна.

Хавсралт 6 хуудастай.

ЗАХИРАЛ



Ц.АМАРСАНАА

152203485

## ТАНИЛЦУУЛГА

2022 оны энхий хагас жилийн байдлаар Барилгын хөгжлийн төв, албан тушаалтанд хандаж иргээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тухай

Тайлант хугацаанд тус төв нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн иргэд, байгууллагуудын өргөдөл, гомдлыг хүлээн авч хуульд заасан хугацаанд хариу шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллалаа.

Барилгын хөгжлийн төвд хандан байгууллагын албан хаагчид болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, байгууллагын албан ёсны дижитал програм able бүртгэлд хамруулан, шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээг авлаа. Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэх зохион байгуулалтын хүрээнд удирдлагын цохолтын дагуу холбогдох албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтэд нь бүртгэлээр хяналт тавин ажилласан.

Иргэд, ажилтнуудаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг аль болох хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажилласан. 2022 оны энхий хагас жилд тус байгууллагад нийт **105** өргөдөл бичгээр, **8** гомдол ирүүлснийг хүлээн авч, бүртгэн, ангилж удирдлагын заалтаар холбогдох хэлтсийн хариуцсан албан тушаалтанд шилжүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлэхэд хяналт тавин, хариу өгч ажилласан.

### *Хүснэгт 1: Өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилбал: /иргэнээс/*

Д/д	Илгээгч	Ангилал		Данс андуурсан гүйлгээ гэх мэт санхүүтэй холбоотой	Хүсэлт гаргах тухай	Архивын хуулбар авах тухай	Тэтгэмж хүсэх тухай	Тодорхойлолт хүсэх тухай	Бусад
		Өргөдөл	Гомдол						
1	Иргэнээс	105	8	39	11	6	10	5	34

Тус байгууллагад нийт **113** өргөдөл, гомдол ирүүлсэн байна. Иргэдээс ирүүлсэн нийт өргөдлийн агуулга нь архивын хуулбар авах, ажилд орох, ахмад настны тэтгэмж хүсэх, тодорхойлолт авах тухай зэрэг асуудлууд голлон зонхилж байна.

**Хүснэгт 2: Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хувиар харуулбал:**

Ирсэн бичиг	Бүгд	Хариутай	Хариугүй	Шийдвэрлэсэн	Хугацаа сунгасан	Хяналтанд байгаа	Шийдвэрлэлт хувиар	Байгууллагад эзлэх хувь
<b>Нийт</b>	<b>113</b>	<b>110</b>	<b>-</b>	<b>99</b>	<b>-</b>	<b>11</b>	<b>90.3%</b>	<b>100%</b>

Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн нь **90.3%**-н үзүүлэлттэй байгаа бөгөөд 11 өргөдлийн хугацаа болоогүй хяналтад байна. Шийдвэрлэлтийн явц нь **8-9** хоног.

Захиргаа, удирдлагын хэлтсээс өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж биелэлтийг тооцон ажилласан байна.

**БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ  
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС**

**"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-т иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын тайлан**

Эхлэл 2022/01/03 Даваа гариг Төгсгөл 2022/07/04 Даваа гариг Нийт урт Хуанлийн 183 өдөр		ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ТАЙЛАН [Хүлээн авсан огноогоор]					Дэлгэцэнд 113 өргөдөл гомдол Төрөл Нэр дээр байгаа бичгүүдийн тайлан			
Салбар хэлтэс	Бүгд	Хуудас	Хариутай	Шийдвэр лэсэн	Хяналтанд байгаа	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэлт -ийн хувь	Байгууллагад ээлэх хувь	Гүйцэтгэлийн дундаж өдөр	
Удирдах ажилтнууд	7	7	6	0	6	0		6.19%		
Захиргаа, удирдлагын хэлтэс	31	34	31	29	2	0	93.55%	27.43%		
Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтэс	27	37	27	25	2	2	92.59%	23.89%		
Норм, нормативын хэлтэс	4	4	4	4			100%	3.54%		
Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтэс	2	2	2	2			100%	1.77%		
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэс	4	4	4	4			100%	3.54%		
Барилгын материалын сорилт, шинжилгээний лаборатори	1	1	1	1			100%	0.88%		
Барилга байгууламжийн зураг төсөл магадлалын хэлтэс	8	12	7	6	1		85.71%	7.08%		
Сургалт, судалгаа мэдээллийн хэлтэс	6	6	6	6			100%	5.31%		
Нийтийн аж ахуйн хэлтэс	8	8	8	8			100%	7.08%		
Хот суурин, дэд бүтцийн судалгаа төлөвлөлтийн хэлтэс				0						
Хүн амын нутагшилт, бүс нутгийн судалгаа, төлөвлөлтийн хэлтэс	15	15	14	14			100%	13.27%		
<b>Нийт</b>	<b>113</b>	<b>130</b>	<b>110</b>	<b>99</b>	<b>11</b>	<b>0</b>	<b>90%</b>	<b>100%</b>	<b>0</b>	

**Барилга, хот байгуулалтын яам болон түүний харъяа байгууллага, албан тушаалтанд  
хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал  
/2022 оны энхний хагас жилийн байдлаар/**

Хавсралт №1

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Нийт шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо	Үүнээс		Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт %/
				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	БХТ ТӨААТҮГ	255	239	-	-	13	94.92.0%
	<b>Дүн</b>	<b>255</b>	<b>239</b>	-	-	<b>13</b>	<b>94.92%</b>

**Хүснэгт 1: Өргөдөл, гомдолын шийдвэрлэлтийг хувиар харуулбал /иргэнээс/:**

Ирсэн бичиг	Бүгд	Хариутай	Хариугүй	Шийдвэрлэсэн	Хугацаа сунгасан	Хяналтанд байгаа	Шийдвэрлэлт хувиар	Байгууллагад эзлэх хувь
<b>Нийт</b>	<b>113</b>	<b>110</b>	<b>0</b>	<b>99</b>	-	<b>11</b>	<b>90.3%</b>	<b>100%</b>

**Барилга, хот байгуулалтын яам болон түүний харъяа байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, хүсэлтийн агуулга /хувиар/  
/2022 оны эхний хагас жилийн байдлаар/**

Хавсралт №2

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Барилгын хөгжлийн төв	<p><b>Нийт 113 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс:</b></p> <p align="right"><b>1. Хүсэлт 105 /93.0%/</b> <b>2. Гомдол 8 /7%/</b></p> <p><b>- Хүсэлт 105 /93.0%/</b></p> <p>Иргэдээс ирүүлсэн нийт өргөдлийн агуулга нь архивын хуулбар авах, ажилд орох, ахмад настны тэтгэмж хүсэх, тодорхойлолт авах тухай зэрэг асуудлууд голлон зонхилж байна.</p> <p><b>- Гомдол 8 /7.0%/</b></p> <p>Тайлант хугацаанд утсаар 8 гомдол ирсэн. /Бичгээр-7, утсаар-1/</p> <ol style="list-style-type: none"> <li>Иргэн Ж.Мягмарсүрэн нь төслийн менежер ба зураг төсөл зохиох зөвлөх үйлчилгээний гэрээг БХБЯ-тай байгуулан ажилладаг. Гэрээт ажлын захиалагчийн техникийн хяналтыг манай байгууллагаар хянуулж байгаа ба энэхүү төслийг хянахаар томилогдсон мэргэжилтэнг өөр мэргэжилтнээр солиулах өргөдөл ирүүлсэн байна. Дээрх өргөдлийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж асуудлыг шийдвэрлэсэн болно.</li> <li>Иргэн Ж.Лхагвасүрэн Магадлал хийсэн ажлын хөлс авах өргөдөл гаргасан ба ажлын хэсэг хуралдаж өргөдөлд дурдсан асуудлыг шийдвэрлэсэн байна.</li> <li>Иргэн Г.Оргилмаа нь “Үерийн далан /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/-ийн барилгын ажлаас шалтгаалж оршин суугчдад хохирол учирсан тухай гомдол гаргасан ба 2/702 дугаар албан бичгээр хариу өгч асуудлыг шийдвэрлэсэн болно.</li> <li>Иргэн н.Батцэрэн БХБЯ-д хандан “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын талаар гомдол гаргасан бөгөөд гомдол гаргагч иргэнтэй 2022.04.05-ны өдөр холбогдож тодруулга авах гэсэн боловч өөрт тулгарсан</li> </ol>

	<p>асуудлаа шийдвэрлэсэн өргөдлөө буцаан татан авсан гэх мэдээлэл өгсөн болно.</p> <p>5. “Герман Монгол Пропертиз” ХХК-ийн Итгэмжлэгдсэн төлөөлөгч П.Итгэл барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт хууль бус, үндэслэлгүй тул хүчингүй болгох өргөдөл, гомдол гаргасан байна. Өргөдлийн дагуу холбогдож Улсын комисс зохион байгуулах байгууллага болох Хотын стандарт, хяналтын газарт хандахыг зөвлөсөн болно.</p> <p>6. Иргэн Ё.Шинэцэцэг Шинжээчийн төлбөр авах гомдол ирүүлсэн Тус гомдолд 1/822 дугаар албан бичгээр хариу өгч асуудлыг шийдвэрлэсэн байна.</p> <p>7. Иргэн Г.Уугандож “Жун чан пропеоти” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан эсэх асуудлаар гомдол гаргасан. Тус чиг үүргийг хэрэгжүүлдэггүй тул холбогдох хууль, хяналтын байгууллагад хандахыг зөвлөн 1/1177 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн болно.</p> <p>8. Иргэн Д.Ганбат “Соронз корпорейшн” ХХК-ийн барилгын үйл ажиллагаанй тусгай зөвшөөрлийг цуцлцлах тухай гомдол 2022.07.04-ний өдөр ирүүлсэн байна.</p>
--	--